



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №15

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2023 оны 12 дүгээр сарын 25 наас 2024 оны 01 дүгээр сарын 29 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2023 оны 12 дүгээр сарын 25 наас 2024 оны 01 дүгээр сарын 29 ний хооронд шувууны томуугийн А хүрээний Н9N2, Н3N8, Н7N9, Н6N1, Н10N8, Н7N4, Н5N8, Н10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Камбоджи улсын Прейвэнг, Сиенрейм мужид өндөр хоруу чанартай шувууны томуугийн Н5N1 хэвшинжээр хүн өвдсөн 2 тохиолдол бүртгэгдэв. *Эхний тохиолдол:* 3 настай хүүхдийн гэрийн ойролцоо шувууд 10 хоногийн өмнө үхэж байсан бол *хоёрдах тохиолдол:* 69 настай өвчтөн нь гэртээ 50-60 тооны тахиа тэжээдэг ба шувууд нь 2 долоо хоногийн өмнөөс үхсэн өгүүлэмжтэй байна.

Мөн БНХАУ-ын Сичуан мужийн Зияанг хотод шувууны томуугийн Н5N6 хэвшинжээр хүн өвчилсөн 1 тохиолдол бүртгэсэн тухай 2024 оны 01 дүгээр сарын 16 нд мэдээлэв. 59 настай эмэгтэй шинж тэмдэг илрэхээс өмнө шувууны худалдааны захаар орж байсан. 11 дүгээр сарын 29 нөөс хүндэрч эмнэлэгт эмчлэгдсэн байна. Иймээс өвчлөл бүртгэгдсэн тухайн улсын шувууны аж ахуй, худалдааны төвүүдээр зорчихгүй байх, зорчсон тохиолдолд амны хаалт зүүх, гараа угаах, ариутгах арга хэмжээг авах талаар зөвлөгөө, зөвлөмж өгсөн байна.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2023 оны 12 дугаар сарын 25 наас 2024 оны 01 дүгээр сарын 29 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Австри, Белги, Камбоджи, Канад, БНХАУ, Дани, Франц, Грек, Герман, Хонг Конг, Унгар, Украин, Исланд, Изриаль, Итали, Япон, Казахстан, Молдав, Нидерланд, Норвеги, Польш, Португал, БНСУ, Румын, Өмнөд Африк, Испани, Швед, Швейцарь, Тайвань, Их Британи зэрэг 31 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 272 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Африк, Америк тивийн улс оронд шувууны аж ахуйд, Зүүн Азийн улс оронд (БНСУ, Япон) өвөлжихөөр очсон тогоруу, хун, галуу, нугасны төрлийн шувуудаас өвчлөл бүртгэгдсэн. Антарктидын ойролцоо арлуудад далайн эргийн хөхтөн амьтан болон шувуудын дунд өндөр хоруу шувууны томуугийн Н5N1 хэвшинжийн вирус 2024 оны 1-р сараас бүртгэгдэж эхэлсэн.

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Шувууны аж ахуй	30
H5N1	Австри	Шувууны аж ахуй, гунгар хун, начин шонхор	7
H5N1	Белги	Тахианы аж ахуй, галуу, шилийн сар	4
H5N1	Камбоджи	Тахианы аж ахуй	3
H5N1	Канад	Тахианы аж ахуй	1
H5N6	БНХАУ	Тодорхойгүй	1
H5N1	Дани	Галуу, эгэл шонхор, <i>Branta leucopsis</i> , шилийн сар	15
H5N1	Чех	Шувууны аж ахуй	8
H5, H5N1	Франц	Хун, тахианы аж ахуй	5
H5N1, H5N5	Герман	Хун, нугас, цахлай, тахиа, цацагт хяруулын аж ахуй	30
H5N1	Грек	Тахианы аж ахуй	9
H5N1	Хонг Конг	Зээрд нугас	1
H5N1	Унгар	Галуу, нугас, тогоруу, идлэг шонхор, шувууны аж ахуй	14
H5N1	Итали	Зээрд нугас, ногоохон нугас	2
H5N1, H5N5	Япон	Гангар хун, тогоруу, хэрээ, эгэл шонхор, шар шувуу	31
H5N1	Казахстан	Гунгар хун	1
H5N1	Молдав	Гангар хун, эгэл шонхор, шувууны аж ахуй, цахлай, шилийн сар	32
H5N1	Нидерланд	Галуу, <i>Branta leucopsis</i> , цахлай	9
H5N1, H5N5	Норвеги	Цагаан сүүлт бүргэд, шар шувуу	2
H5N1	Польш	Бор галуу, гунгар хун, шувууны аж ахуй	13
H5N1	Португал	Цахлай	1
H5N3, H5N6, H5N1	БНСУ	Гангар хун, зэрлэг нугас, шувууны аж ахуй, мандарин нугас	17
H5N1	Румын	Гунгар хун, гангар хун, шувууны аж ахуй	12
H7N6, H5	Өмнөд Африк	Тодорхойгүй	7
H5N1	Испани	Тогоруу, цахлай	4
H5N1	Швед	<i>Branta leucopsis</i> , шувууны аж ахуй, зэрлэг нугас	13
H5N1	Швейцарь	Хун	1
H5N1	Тайвань	Тахианы аж ахуй	3
H5N1	Украйн	Шувууны аж ахуй	4
H5N1	Их Британи	2 зүйл хун	3
H5N1	Антарктик	Цахлай <i>Stercorarius antarcticus</i> , <i>Larus dominicanus</i> , <i>Sterna vittata</i> , 2 зүйл далайн хав	1

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 2. 2023 оны 12-р сарын 25 наас 2024 оны 01-р сарын 29 **ний** хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт

